

Одмандах М.

ОРОСЫН ҮНЭН АЛДАРТНЫ ШАШНЫГ МОНГОЛД ДЭЛГЭРҮҮЛЭХ ОРОЛДЛОГО
(TUYATU LÜNGDÜNG KEMEKÜ NOM ORUSIBAI)

Монголын газар нутгаас христийн шашин, тэр дундаас оросын үнэн алдартны шашныг олон түмэнд түгээж байсны баримт болсон монгол бичгээр найм, төвд үсгээр монгол хэлээр бичсэн нэг гар бичмэл судар олдлоо. Иймд бид «Туяат лүндэн хэмээх судар оршив» хэмээх тус судрын хувилбаруудыг танилцуулж, түүхэн үндэс, зохиогчийн тухай таамаг дэвшүүлсэн энэхүү өгүүллийг бичив.

Тус судрын цорын ганц судалгаа нь дорно дахиныг судлагч Германы эрдэмтэн Фридрих Александр Бишофф 1957 онд монголоос хоёр эх олж, хуулбар хийн, эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж *Monumenta Serica, Journal of Oriental Studies*¹ сэтгүүл (Vol. XX. 1961)-д олж авсан судрынхаа эх, эрдэм шинжилгээний галигийг хэвлүүлж, тодорхой тайлбар зүүлт хийжээ.

Тулхуур үг: Туяат лүндэн, судар, үнэн алдартны шашин, хуулбар, галиг үсэг

К ВОПРОСУ О РАСПРОСТРАНЕНИИ ПРАВОСЛАВИЯ В МОНГОЛИИ

В настоящей статье рассмотрены списки христианского сочинения «*tuyatu lüngdüng kemekü nom orusibai*» (Лучезарная проповедь): 8 сочинений на монгольской классической письменности и одно сочинение на монгольском языке, записанное тибетскими буквами. Следует отметить, что данные тексты привлекали внимание германского исследователя Ф. А. Бишоффа, опубликовавшего с комментариями два известных ему списка. Бытование рукописных версий сочинения в Монголии свидетельствуют о распространении русского православия среди монголов, в связи с чем подняты вопросы об авторе произведения, времени составления и

¹ Bischoff F. A. Eine Buddhistische wiedergabe christlicher bräuche: Glanzvolles Manifest Genanntes Sūtra // *Monumenta Serica. Journal of Oriental Studies*. Vol. XX. 1961. P. 282-310.

исторических условиях. Статья дополнена транслитерацией и переложением на кириллицу списка А.

Ключевые слова: «Лучезарная проповедь», православие, источник, транслитерация

Odmandakh M.

TO THE QUESTION OF THE SPREAD OF ORTHODOXY IN MONGOLIA

We studied 8 texts of an old book entitled as «Tuyatu lüngdүng kemekү orusibai», which was compiled on the «21st of the final month of the sheep year», in 1883, written in Mongolian language and a text in Mongolian language rendered by Tibetan letters. In the article their analysis, the historic background of their translation is analyzed.

This book was compiled with the aim of acquainting the public with the Orthodox religion. More precisely, this book was written specially for the Buryat-Mongols for teaching them the Orthodox religious doctrine.

We found out that this book was rendered by a Mongolian lama, after visiting the lectures about the Orthodox religion. We came to such a conclusion because of several reasons. First of all, in this book there are phrases and a line that are missing in the biblical book, as well as we found a wrong writing of a name and several terms. This occurred probably due to a misunderstanding of religious interpretations. We suppose that a man of Buryat-Mongolian origin, knowing the Russian language, wrote this text. Additional evidence of this fact is that the style of the text and the phrases reflect the dialect features of the Buryat-Mongols.

This text has been studied for the first time by F. A. Bishoff. Who has published the results of his researches in 1961.

Keywords: Tuyatu lunden, source, Christianity, copy, transliteration

Судруудын шинж байдлын тодорхойлолт

Бид энэ удаа Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын 6-р багийн өндөр настан Д. Ханд гуайн эхийг «Хувилбар А» [16] гэв. Харин Дорноговь аймгийн Сайншанд хотын лам М. Дорждэрэм гуайд буй төвд үсгээр бичсэнийг «Хувилбар Б» [17], Монгол улсын Үндэсний нийтийн номын санд буй 3967/96 кодтой байгааг «Хувилбар В» [18] гээд хамт байгаа хоёр тусдаа эхүүдийг «В-1», «В-2» ялгаж тэмдэглэв. Мөн Улаанбаатар хотын Эртний эдлэлийн

нэгэн дэлгүүрээс авсаныг «Хувилбар Г» [19], Германы эрдэмтэн Ф. А. Бишофын өгүүлэлдээ А, Б гэж нэрлэсэн хоёр эхийг «Хувилбар Д», «Хувилбар Е» [Bischoff, 1961: 298] гэв. ШУА-ийн ХЗХ-ийн Төвд судлалын тасгийн В0339 кодтойг «Хувилбар Ё» [20], В70 дугаартайг «Хувилбар Ж» [21] гэж нэрлэж эх бичгийн судалгааг танилцууля.


Тус судрын бас нэг хуулбар Булган аймгийн Бүрэгхангай сумын хийдэд, өөр нэг хувь Хэнтий аймгийн Музейд байгаа сурагтай.

Судрын товч танилцуулга

Хувилбар А. «[16] «Tuayatu lüngdüng kemekü nom orusibai» хэмээх судар нь 32.8 x 10.5 см-ын хэмжээтэй орос дэвтрийн тууш шугамтай цаасан дээр бичсэн 3 нүүр хуудас бүхий 30-31 мөрөөр бичсэн гар бичмэл. Оросын тууш шугамтай дэвтрийг дундуур нь зүсэж хувааж, ягаан өнгийн бэхтэй үзгээр, таталган хэвээр буриад аялгуугаар бичсэн. Цаас нь булан дээрээ 143, 144, 135, 136 гэсэн дугаартай. Ягаан, цэнхэр өнгийн шугамтай, дэвтрийн хавтас, мөн нэг хуудсаар хичээнгүйлэн нугалж боосон. Бичсэн дэвтэр нь төмөр замын ажилчдын тэмдэглэл хөтөлдөг дэвтэр² байх магадлалтай. Орос дэвтрийн хавтасаар боож, дотор нь мөн үргэлж нэг хуудсыг хичээнгүйлэн нугалж боосон. Хавтас нь «ТЕТРАДЬ» гэсэн 12 хуудастай, 17 копкеийн үнэ бүхий «Пензенская бумажная фабрика "Маяк революции"» г. Пенза. ГОСТ 204-50. Артикул 601. IV квартал 1955 г.» гэсэн байгаа нь уг судрыг хадгалахдаа шинээр хийсэн ажээ.

² «Туяат лүндэн хэмээх ном оршив» хэмээх судрыг хуулбарласан цаас нь Оросод үйлдвэрлэгдсэн дэвтрийн цаас болно. Үйлдвэрээс дэвтрийн хүрээг тод ягаан, улаан өнгөөр хүрээлсэн, босоо өндөр дэвтрийг хоёр хувааж бичсэн. Дээд хүрээг нь өргөн болон нарийн зураасаар давхар хүрээлсэн, хажуу шугам нь хоёр зэрэгцээ байдлаар татагдсан. 144, 143, 135, 136 гэсэн дэвтрийн хуудасны дугаартай. Дугаарыг Араб тоогоор тод хараар бичсэн нь цаасны үйлдвэрээс дэвтрийн дугаарыг бичиж хэвлэдэг байсныг гэрчилнэ.

Нүүрэн талд 3.2 х 8.6 см-ийн харьцаатай улаан шугам, мөн дотор талд нь ягаан бэхээр судрын гарчигийг бичсэн. Дотор нүүрэнд судрыг хуулж бичихдээ алдаа мадагтай, баллан сохолж бичсэн, саруудыг оросоор бичсэн, гаргац муутай бичигдсэн. Тус судар нь «...1943 оны 8-р сарын 23-нд буув, төгсөв» гэсэн үгтэй, орчин үеийн үзэг, орос ягаан бэхтэй үзгээр хожуу хуулсан «Хуулбар эх» болох нь харагдаж байна.



Зураг № 1. Хувилбар А-гийн нүүр хуудас

Хувилбар Б. [17] Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Цагаан хадны [Католик шашны сурах бичиг, 2011: 362] хурлын лам Зундуй³ төвд гэдэг хүн анх хуулбарлан тараасан гэсэн домогтой, одоо М. Дорждэрэм гуайд хадгалагдаж байна.

³ Түүний шавь явсан Мятавын Дорждэрэм гуайн өгүүлснээр бол Зундуй гэж нэртэй Төвд лам 1930-аад оны үед урд газраас нэг хүний хамт хоёр дээлийн чичүү үүргэвчиндээ хийж, явган бадарчилж орж ирсэн ажээ. Тэрбээр дээрх судрыг залж ирсэн бөгөөд багш нарынхаа захиасаар олон түмэнд тараах ёстой гэж ярьдаг байсан тухай дурсаж байна. Тэрхүү Зундуй хэмээх төвд лам монгол гэргий авч суурьшсан бөгөөд тэр үедээ шашин дэлгэрүүлсэн хэргээр орон шоронд хүртэл орж явсан тул хар болж амьдардаг байсан байна. Түүний хүү Жамбалданзан гэж хүн амьдарч байжээ. Тэрбээр Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын нутагт аж төрж байсан бөгөөд Чандмань, Цагаан хадны хуралд сууж байсан тухай М. Дэрэм гуай хуучлав.


Уг судар нь 21.5 x 8.8 см хэмжээтэй, тууш дэвтрийн цаасан дээр хар бэхээр, хулсан үзгээр, төвд үсгээр монгол хэлээр бичсэн. Цаас нь удаан хадгалагдсан, байнга уншиж хэрэглэдэг учир сэмэрч муудсан, захаасаа урагдаж, зарим үг бичлэг нь баларсан. Орос тууш дэвтэр, зураас нь бүдэг хар, баларсан маягтай, монгол бичгээр хуудасны дугаар тавьж, бярга үсгээр эхэлж, 11 мөрөөр бичсэн, хавтастай нийлээд 6 нүүр буюу 3 хуудастай. Агуулгаараа бусад хувилбартай ижил боловч зарим үг нь бага зэргийн зөрөөтэй, төвд хүн монгол хэлээр хуулж бичсэн тул хэлзүйн болон галигийн алдаатай. Зарим бичлэг нь гаргац муутай, захаараа урагдсан. Сар өдрийн заримыг нь монголоор бичсэн, 82 хатуу өдрүүдийн тухай дурдсан нь зөрүүтэй.

Бичвэрийн хэмжээ нь 16.5 x 8.0 см хэмжээтэй. Судрын төгсгөлд «Энэхүү усан хонин жилийн өвлийн адаг сарын 20-ны шөнө бичив» гэж төгсгөсөн. Буддын шажны судар бичих, хуулах уламжлалыг баримталсан.

Мөн ийм хуулбарууд Дорноговь аймгийн Сайншанд хотын хийдийн лам нарт мэр сэр байдаг бололтой сургийг нутгийн иргэд гаргаж байсан.

Хувилбар В. [18] Монголын Үндэсний номын сангийн гар бичмэлийн тасагт буй «*tuy-a-tu lüngdüng kemekü sudur orusibai*», 3967/96 (294.1 T727) дугаартай хоёр хувилбар.

Цагаан хадны хурал: Газарзүйн байршил: Хойд: N45⁰43. 91', Зүүн: E111⁰ 04. 083'. Дорноговь аймгийн Дэлгэрэх суман дахь Цагаан хадны хурал нь улсын хилээс 130 км, аймгийн төвөөс 135 км, сумын төвөөс 15 км зайд Цагаан хад хэмээх газар Бүрэнт засагчийн гуравдугаар (1874) онд эмч Лампаран гэгч санаачлан байгуулжээ. Энэхүү хурал нь нэг сүм, 108 ламтай, Их, Чойр, Хайлан, Ганжуур, Донрүв, Баруун, Зүүн, Савчуу зэрэг жижиг дацангуудтай, 70 ам метр талбай эзлэн оршдог байжээ. Галбын говийн Галбын ууланд энэ хурлыг ноён хутагт Данзанравжаа үндэслэн байгуулжээ. Галбын гурван хийд гэдэг нь Цагаан хадны хурал, Дэмчигийн сүм, Галбын улаан сахиусны эдгээр гурван хийдийг хэлнэ. Эдгээр хийдүүд нь Галбын ууланд оршиж байв. «Монголын сүм хийдийн түүхэн товчоон» /2009/ номын 362-р талд.



Зураг № 2. Хувилбар Б-гийн нүүр хуудас

Хувилбар В-1. «*tuy-a-tu lüngdüng kemekü sudur orusibai*» гэсэн нэртэй, орос тууш дэвтрийн нэг талын хуудсыг нугалж, дундуур нь зүсэж, сударлаж бэлтгэн, хар бэхээр үзгээр хуулж бичсэн 11 нүүр, таталган хэвээр бичсэн.

Хавтсанд гарчигийг хар өнгийн бэхээр бага зэрэг таталж бичсэн, гарчигийг тойруулан улаан, хөх орос будгийн харандаагаар гурван давхар хүрээ татаж, шар, ногоон өнгийн харандаагаар дүүргэж будсан. Судрын «туяат» гэдэг нэрийг монгол бичгээр буруу бичсэн. Үг үсгийг дуудлагаараа алдаа ихтэй бичсэн. Гадна талд нь 624 гэсэн тоог ягаан бэхтэй үзгээр номын санч нар гадна кодыг бичсэн үзгээрээ уг тоог тэмдэглэсэн. «Улсын номын сан» гэж монгол бичгийн дардастай. Дардас нь хар, хөх, ягаандуу өнгөтэй.

Гадуураа бор зузаан цаасаар хавтас, баринтаг маягаар хийсэн. Судрыг ар өвөргүй хуулсан, 6 хуудастай. Дугаарыг зөвхөн эхний нүүрэнд нь монгол тоогоор тэмдэглэсэн. Судрын төгсгөлд нь жилийн 12 сарыг монгол бичгээр тоог нь тавьж, оросоор монгол бичгээр галигласан. Төгсгөл нь эхлэлийн адил улаан өнгөөр нэг, хөх өнгийн харандаагаар хоёр давхар хүрээ татаж, шар өнгийн харандаагаар будсан. Ингэхэд ногоон өнгө ялгарч гарсан. Уг гар бичмэлийг нугалсан оромтой. Хэн анх хуулсан, номын санд хэн өгсөн, хэдий үед хамаарах тухай эх бичгийн тодорхойлолт үгүй.

Судрын найман нүүрийг 17-18, хоёр нүүрийг 13-14 мөрөөр бичсэн. «Усан хонин жилийн өвлийн адаг сарын 21-ний өдөр бичив» гэсэн боловч өөр эхээс дамжуулан хуулсан эх гэж үзмээр.

Хувилбар В-2. «Tuy-a-tu lüngdüng bolai» нэртэй тус хуулбар нь хортой харандаагаар хоёр давхар хүрээ татсан, гадуур болон дотор талаар нь хээгээр чимэглэсэн, хээг ягаан бэхээр мушгирсан хээ зурсан, 9 нүүртэй, дэвтрийг сударлаж бичсэн. Хэмжээ нь 18 x 8 см. Төгсгөлд нь «ум ма ни бад мэй хум» гэж бичсэн. Зарим үг үсэг нь гаргагдахгүй, баларсан, гадаад үгийг монгол бичгээр алдаатай хуулсан, буриад хүн бичсэн бололтой. Хэзээ, хэдийд хуулсан тухай ямар нэгэн тэмдэглэлгүй.

Дотор нь үг үсгийн алдаа ихтэй, дуудлагаараа бичсэн, буриад аялганы үг ихтэй, зарим үгийг оросоор нь буулгасан, галигийн алдаатай хуулсан эх. Хорын харандаа нь мөн л оросод үйлдвэрлэж, манайд дээрхэн үед түгээмэл хэрэглэдэг байсан тул анхны эхээс сүүлд дахин хуулж хадгалсан байх магадлал өндөр.

Хувилбар Г. [19] «Tuyayatu lüngdüng kemekü sudur-a ogusibai» хэмээх судар нь 20.5 x 7 см харьцаатай орос шаргал цаасыг судар бичихэд зориулан тусгайлан янзалж бичсэн 6 хуудас, 12 нүүр бүхий хар өнгийн бэхээр төмөр (гуурсан) үзгээр 21-22 мөрөөр бичсэн гар бичмэл судар. «Лүндэн» гэдэг үгийг буруу бичиж, мөн «Судар» гэдэг үгийг ардаа орхиц «-а»-тай бичсэн.

Гадна нүүрний судрын нэрийг дээрээс нь шар өнгийн будгийн харандаагаар зурж, тодруулсан, гарчигийн гурван үгийн доод хэсгийг тааруулан хувийн тамга дарсан, тамга нь алхан хээгээр хүрээлсэн, дун урлан сийлсэн, улаан тосон тамгатай. Судрыг хуулахдаа цаасыг хөдөлгөхгүйн тулд цаасны хоёр талд цоолж, хадаас, хурц зүйлээр тогтоож бичсэн оромтой, 2-3-р хуудасны хажуу буланд «Фабрики наследниковь Сумкина»⁴ гэсэн тамгатай



⁴ А. С. Сумкины цаасны үйлдвэр нь Оросын Лальск хотод 1829 онд анх байгуулагдаж байсан тухайн үеийн хамгийн томд тооцогдох үйлдвэр байжээ. Тиймээс тус цаасыг Сибирийн модоор хийж байсан тул энэ бүс нутагт хамгийн өргөн дэлгэр хэрэглэгдэж байсан байна. Энэ талаарх

байгаа нь Сибирт байсан А. С. Сумкиний [Цэрэнчимэд, 2009: 2] үйлдвэрийн дэвтэр болохыг илтгэнэ.

Уг эхийг 18.3 х 6.2 см хэмжээ бүхий хоёр давхар хүрээг ягаан өнгийн бэхээр татсан, хуудас бүрийг монгол бичгийн тоогоор дугаарлаж бичсэн, хамгийн төгсгөлийн хуудасны ар талд эхлээд буруу бичигдсэн тул түүнийг баллаж, хамгийн эхний хуудсыг шинээр хуулж бичсэн, бичээсийн хэмжээ нь 18 х 6 см-т багтсан, «Сарва мангалам» гэсэн санскрит үгийг судрын төгсгөлд бичдэг уламжлалыг дагасан, хувийн тамгаа мөн дарсан. Маш сайн гаргацтай, цэвэрхэн хуулсан, их сайн хадгалагдсан. Энэ нь судрын нүүрэнд болон төгсгөлд нь «Мамба» гэсэн бичигтэй, алхан хээгээр хүрээлсэн, дунд нь дунг хадган дээр залж хийсэн улаан тосон тамга байгаа бөгөөд энэ нь Богдын хиагийн хүү Дашзэвэг эмчид хадгалагдаж байсныг судлаач Г. Ням-Очир тогтоосон.

Хувилбар Д. [Bischoff, 1961: 290] А гэж нэрлэгдсэн тус судрын талаар Ф. А. Бишофын бичсэн тодорхойлолтыг энд оруулав. Үүнд: «... Энэхүү (А) хуулбар энэ нийтлэлд хэвлэгдсэн байгаа. 21 х 8,5 см хэмжээтэй, 7 бүлэг, барагцаагаар 16 багана бүхий тус гар бичвэрийг налуу бичгээр ар өвөргүй бичжээ. Дан хүрээтэй, зүүн гар талаас (урд) 1-7 хүртэл дугаарласан ба 1-р бүлгийн дээд талд гарчиг, 7-р бүлэг нь хоосон. Эх хувийг харандаагаар шугамдсан, барууны гаралтай цаасан дээр хар бэхээр ташуу бичжээ. Судрын өөр нэг хувилбарыг Хэнтий аймагт бидний буудалласан отгийн эзэн хэд хоногийн дараа профессор Содномд бэлэглэсэн юм. Түүнийг *Vajracchedika (Tib.)*, *Ki Morin-u sang, ganjuur tanjuur-uun quriyaqui orosiba, nigül arilsugai sudur orosiba* хэмээх 4 судартай хамт баринтагласан байсан. (*Ki Morin-u sang, ganjuur tanjuur – uun quriyaqui orosiba, nigul arilsugai sudur orosiba*) хэмээх 3 судрын хуулбарыг би европ руу авч явсан бөгөөд баруун Германы

Магбург хотын номын санд Ms; Hs of 288; 289; 287 гэсэн кодтой хадгалагдаж байгаа...» [Bischoff, 1961: 282] гэжээ.



Зураг № 3. Хувилбар Г-гийн нүүр болон арын хуудас

Бярга үсгээр эхэлсэн, «Тууау-а-tu lüngdeng kemekü sudur oruṣiba» гэж бичсэн, гарчигийг давхар хүрээнд бичсэн, судрыг эхлэхдээ мөн «Бярга» үсгээр эхэлсэн, судрын хуудасны эхний нүүрийг үгээр бичиж дугаарласан, хэлбэр муутай бичгийн хэвтэй, дармал болон бичмэл тигийг хольж бичсэн, төгсгөлд нь «Усан хонин жилийн өвлийн адаг сарын хорин нэгний өдөр бичив» гээд «Сарва мангалам», «Сайн буюу дэлгэрэх болтугай» гэж төгсгөсөн. Энэ нь 1957 онд уг эхээс нь Бишофт хуулж өгсөн хуулбар эх, жинхэнэ эхийг нь бид олж үзээгүй.

Хувилбар Е. [Bischoff, 1961: 294] Мөн «... Профессор Содном Улаанбаатар дахь Шинжлэх Ухааны Хороонд лүндэнгийн 2 дахь хувилбарыг үг үсэггүй хуулбарлан бичүүлсэн бөгөөд 21 x 8,5 см

хэмжээтэй, 7 бүлэг, барагцаагаар 18 багана бүхий тус гар бичвэрийг ташуу бичгээр, давхар хүрээнд ар өвөргүй бичиж, зүүн гар талаас (урд) 1-6 хүртэл дугаарлажээ. Хавтсыг дугаарлаагүй бөгөөд зөвхөн гарчигийг бичсэн. Эх хувь нь улаан бэхээр дөрвөлжин шугамтай цаасан дээр ташуу бичсэн, давхар хүрээг ногоон-бэхэн ягаан, цэнхэр-бэхэн ягаан өнгийн харандаагаар татсан. Энэхүү *лүндэнгийн* 2 дахь хувилбарыг нийтлэлд зүүлт тайлбараар оруулж өгсөн. Маш олон хувилбартай. (2б) хувилбарт дурьдагдаагүй хааны эсрэг байх эрх та нарт бий хэмээх анхааруулгыг эс тооцвол А болон Б хувилбаруудын ерөнхий утга адилхан. Б нь А судрыг бодвол арай богино бөгөөд ярианы хэлний хэлбэрийг чухалчилсан, араб болон төвд цифрээр бичсэн. А, Б текстийг энэхүү өгүүллийн 290-298 хуудаст фото механик аргаар хэвлэсэн. Б текстийн төгсгөлд байгаа тамга нь миний өөрийнх...» [Bischoff, 1961: 283] гэжээ.

Мөн тус «*Tuayaatu lüngdüng kemekü sudur orusbai*» нэртэй, хоёр давхар хүрээнд шугам татаж хийсэн, бичвэрийг мөн ялгаагүй хоёр давхар шугам татаж бичсэн, хуудасны дугаарыг хуудсны өвөр, нүүрэн талд үгээр бичсэн. Судрын төгсгөлд Ф. А. Бишофф өөрийн хувийн тамгаа дарсан. Төгсгөлийн үг нь «Үүнийг усан хонин жилийн өвлийн адаг сарын 2-ны өдөр бичив» гээд «Сарва мангалам» гэдэг үгтэй. Бусдаас ялгаатай нь ихэнх судар 21-нд бичигдсэн байтал уг судар 2-нд гэсэн нь анхаарал татаж байна. Гэхдээ энэ бол 1957 онд Бишоффт хуулж өгсөн хуулбар, жинхэнэ эхийг нь бид олж үзээгүй.

«... Профессор Содномд Б хувилбарыг бэлэглэхээс хагас цагийн өмнө 3 дахь хувийг Хэнтий аймгийн орон нутгийн музейгээс олсон ба хуулбарлах цаг бидэнд байгаагүй. Гадаад байдал нь эхний хоёр судартай маш төстэй, данс тооцооны дэвтрээс салгаж авсан гэмээр хуудсан дээр бичсэн ба (*cf. оyun tülkigür neretei sastir No. 37; Дамдинсүрэнгийн эх бичвэр, С.С.М. XIV, р. 51 тэмдэглэгээтэй*) *Boγda Chinggis qagan-u оyun tülkigür* болон *tabun tngri-yin sang*

судартай хамт баринтагласан байсан...» [Bischoff, 1961: 282] гэснийг нягтлууштай.

Хувилбар Ё. [20] ШУА-ийн ХЗХ-ийн Төвд судлалын тасгийн В0339 дугаартай «Тууауату лүндүнг кемекү судур орусибай» нэртэй судар нь «Хувилбар А»-г бичсэн цаастай адил цаасан дээр буулгасан, 17 х 10.5 см-ийн харьцаатай, 17 мөрөөр бичсэн, 8 нүүртэй судар. Судрын нэрийг дэвтрийн хүрээг ашиглан, босоо зураасаар дөрвөлжин үүсгэж бичсэн. Бярга үсгээр эхэлсэн, бичмэл тигээр, хортой харандаагаар хуулсан, энд тэнд нь зарим үгийг баллаж, сохолсон, дарж дахин бичих зэргээр янзалсан. Нэлээд хожуу хуулсан байх магадлалтай. Дэвтрийн цаас нь орос үйлдвэрийнх болох нь өмнөх «Хувилбар А»-г бичсэн цаастай ижил байгаагаас харагдана.

Төгсгөлд нь «Үүнийг усан хонин жилийн өвлийн адаг сарын хорин нэгэнд бичив» гээд «Сарва мангалам» гэдэг үгээр төгсгөсөн боловч түүний доод талд салангид байдлаар хэдэн үг татлан бичсэн нь гаргац муутай. Төгсгөлд нь хуулсан хүний гарын үсэг бололтой хурдан таталж бичсэн тул гаргагдахгүй болжээ. Судрыг хаанаас хэнээс, хэзээ олж авсан тухай ямар нэгэн тэмдэглэл байхгүй.


Хувилбар Ж. [21] ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Төвд судлалын тасагт В70 дугаартай «Тууау-а-ту лүндүнг кемекү судур орусибай» судар нь бусад эхүүдээс бага зэрэг ялгаатай. Учир нь бор шаргал цаасыг нугалж бичихдээ зөвхөн гадна талд нь хуулбарлаж, дотор талыг нь нугалж хоосон үлдээсэн нь судрыг дараа нь дэлгэж үзэхэд илүү тохиромжтой байсан бололтой. Нийт 8 нүүртэй, ар тал нь хоосон, нугалсантайгаа нийлээд 16 нүүр боловч, нэг талыг нь огт ашиглаагүй. Ам нь нээгдэх талын дотор талд нь бичээгүй, нугалаатай битүү талаар нь эргүүлж үзэхээр хийсэн.

Цаасны хэмжээ нь 21.3 х 8.8 см, тойруулаад шатсан нь галд шатааж байсан ном судраас олж авсан байх магадлалтай. Хуудсыг монгол бичгийн тоогоор дугаарласан. 3-4-р хуудасны дээд доод хэсэгт хар бэхээ асгаж халтартуулсан, үг үсэг нь баларч

харагдахгүй болсон. Бэхэнд дүрдэг төмөр үзгээр бичсэн, бичвэрийн зарим мөр нь тод байхад арагшлах тусам 3-4 мөр нь бүдгэрч, дараагийн мөр нь тод.

Эхний нүүрэнд нэрийг бичсэн, дээд талд хар бэхээр 13, доод талд нь улаан өнгийн харандаагаар 15-ыг монгол бичгээр бичсэн. Хуудас бүрийг 1-8 хүртэл нүүр бүрт монгол бичгийн тоогоор дугаарласан. Судрыг 17, 16, 17, 15, 18, 21 мөрөөр тус тус бичсэн байна. Судрын төгсгөлийн хуудас байхгүй, гээгдсэн. Бусад хувилбаруудаас ажиглахад төгсгөлийн 2-3 мөр дутуу, мөн бусад сударт байгаа хэзээ хуулсныг илтгэх сар өдөртэй төгсгөлийн хуудас нь гээгдсэн бололтой байна.

Цаасны байдал, бичлэгийн тиг, гараар цэвэрхэн, гаргацтай бичсэн зэргээс үзвэл бичгийн өндөр соёлтой жирийн иргэн хуулсан байх боломжтой. Учир нь бярга үсэг байхгүй, судар хуулдаг хайрцагласан хэмжээ, шугам байхгүй, шууд цаасны дээд үзүүрээс доод үзүүр хүртэл тулгаж хуулсан зэргээс тухайн үеийн жирийн бичээч хуулж тараасан байх боломжтой байна.



Зураг № 4. Хувилбар Ж-гийн нэгдүгээр эхлэл хуудас.

Судрыг цаг хугацааг тодруулах асуудалд

Дээрх судрууд нь анхны эхээс хуулбарлагдахдаа бичгийн чадвар харилцан адилгүй хүмүүс бичиж тараасан учраас зарим үг,

өгүүлбэр, тоо, нэр томъёо нь ялгаатай, зөрүүтэй болсон. Эдгээр 9 хувилбарын анхны эх аль нь болох нь мэдэгдээгүй. Уг судар хэдий үеийнх болохыг бид дараах хэдэн зүйлээр тодорхойлов. Үүнд:

1. Дээрх судрын олонх хувилбарууд нь «Үүнийг усан хонин жилийн өвлийн адаг сарын 21-ний өдөр бичив» гэсэн ижил төгсгөлтэй. Энэхүү «усан хонин жил» нь 1883 оны өвөл таарч байна. Энэ талаар эрдэмтэн Ф. А. Бишофф «1883 он байж магадгүй, 1823 он арай эрт, 1943 он хэт хожуу байна» [Bischoff, 1961: 306] гэж тэмдэглэсэн нь бидний саналтай нийцэж байна.

Мөн «буриадчуудын дунд Үнэн алдартны шашны сүмийнхэн баруун буриадчуудад 1825 оноос хойш Христ шашныг дэлгэрүүлэх үйл ажиллагааг эхлүүлсэн» [Арай Юкиясү, 2015: 7] бөгөөд Өвөр Монголчууд библиетэй танилцсан цаг хугацаа 1835 оноос эхэлдэг зэргээс харсан ч ямар ч атугай 1883 он болох нь давхар нотлогдож байна. Хэдийгээр судрын төгсгөлд байгаа сар өдөр нь таарч байгаа боловч нэг өдөр хамтдаа хуулсан гэсэн үг хараахан биш бөгөөд харин анхны эхийг уг өдөр анх бичиж, дараа дараагийн хүмүүс хуулахдаа судрын ард байсан цаг хугацааг тэр чигээр нь хуулсан гэж үзэж байна. Харин «Хувилбар Е» нь «Үүнийг усан хонин жилийн өвлийн адаг сарын 2-ны өдөр бичив» гэж бичсэн нь анхны хуулбар байх боломжтой ч уг эх нь бичгийн хэв муутай, энгийн үзгээр хуулсан, тоог араб тоогоор бичсэн зэрэг байдлаас үзэхэд анхны эх гэж үзэх үндэс муутай.

Бидэнд буй 9 судрын цаас, бичсэн үзэг, бэх зэргээс үзвэл өөр өөр цагт бичиж тараасан болох нь харагдаж байгаа хэдий ч дараагийн «Усан хонин жил» нь 1943 онд тохиож байгаа тул үүнийг үндэслэл муутай юм. Харин «Хувилбар А» нь 1943 оны 8-р сарын 23-ны өдөр хуулбарласан, орчин үеийн төмөр үзгээр, ягаан бэхээр бичсэн. Энэ бол дам хуулбарлан сүсэг бишрэлтэй хүмүүс дамжуулан хадгалсан байна.

2. Судрын цаас нь хэд хэдэн янз байна. Хувилбаруудыг ихэвчлэн орос цаасан дээр буулгасан гэж дүгнэв. Тухайлбал, «Хувилбар Г»-г хуулсан цаас нь Оросын Лальск хотод ажиллаж

байсан Сумкиний цаасны үйлдвэрийнх болох нь судрын хажууд байх дардаснаас харагдаж байна. Уг үйлдвэр нь Сибирт 1829 онд эхэлсэн [Цэрэнчимэд, 2009: 2] бөгөөд Оросод хувьсгал ялах хүртэл тогтвортой үйл ажиллагаа явуулж байжээ. Тус үйлдвэрийн цаас нь хил залгаа монгол, буриадад түгээмэл хэрэглэгдэж байсан болохыг төвд судрыг хуулж байснаас харж болно. Үүнээс үзэхэд тус судар нь ямар ч атугай ХХ зуунаас өмнө анх бичигдэж, олонд түгсэн болохыг гэрчилж байна.



Зураг № 5. Сумкиний цаасны хэвлэх үйлдвэрийн бүтээгдэхүүн дээрээ дардаг тамганы дардас



Зураг № 6. Сумкиний хэвлэлийн цаасан дээр барласан бурханы шашины судрын хэсэг

3. Судрын цаг хугацааг тогтоох өөр нэг үндэслэл нь «... Февралийн 11-12, июнийн 12-14, сентябрийн 10 гэх мэтийн жил дотор 42 муут өдрүүдэд...» нь угтаа Улаан өндөгний баярын мацаг барих өдөр, Петр-Паулын баяр, Загалмайн өргөмжлөлийн баярын өдрүүдийг хэлж байгаа тул 1880-аад оны үед эдгээр баярууд ямар

өдрүүдэд тохиосныг олох явдал юм. Жил бүр өөр өөр өдрүүдэд тохиодог тул үүнийг хөөж тооцох нь судрын бичигдсэн цаг хугацааг тогтооход нөлөө үзүүлэх магадлалтай.

Энэ бүхнээс тус судар нь билгийн тооллын «Усан хонин жил» буюу аргын тооллын 1883 онд бичсэн болох нь тогтоогдов. Харин цаашид нарийвчилсан судалгааны дүнд судрын жинхэнэ анхны эхийг олвол цаг хугацааг илүү бодитой тогтоох боломжтой. Одоогийн байдлаар бид дээрх 9 хувилбарын аль нь жинхэнэ эх, эсвэл огт өөр эх хувь байсан эсэхийг нягталж амжаагүй байгаа тул ийм дүгнэлтэнд хүрлээ.

Судрын түүхэн үндсийн тухай

«Монголын нууц товчооноос» эхлээд түүхэн баримт, эх сурвалжуудад шашны урсгалууд монголд чөлөөтэй байж, тэр дундаас эзэн Чингисийн үеэс төрд зүтгэгчид төрөл бүрийн шашин шүтлэгтэй байсныг тэмдэглэн үлдээжээ. Мөн монгол угсаат овог аймгуудын дунд христийн загалмай, «несторий» урсгалыг шүтдэг⁵ Найман, Хэрээд, Онгууд [Байгаль, 2011 :423-432] зэрэг аймгууд оршоор ирсэн нь түүхэнд тодорхой байдаг.

Монголд тэр дундаас Өвөрмонголд Христийн шашны Католик⁶ урсгалыг дэлгэрүүлэх ажил эртний улбаатай боловч 1837 оноос сэргэж, Лазарист хэмээх франц шашны бүлгэм орж ирж, улмаар

⁵ Monograph Series Volume 2, Антоон Мостаэрт Монгол судлалын төв, У. Эрдэнэбат «Дундад зууны монгол оронд загалмайгны шашны урсгал нэвтэрч байсан товч түүхээс» / Эрхэлсэн Г. Цэцэгдарь (Улаанбаатар, 2009) бүтээлд христийн шашны урсгалууд хэрхэн дэлгэрч байсан түүхийг бичсэнийг олж үзнэ үү. Тэр дундаас Константинополь хотын хамба лам Несторийн үүсгэсэн шинэ урсгал нь уугуул нутагтаа хавчигдан гадуурхагдаж, дорно зүгт 460-аад оноос хүчтэй тархах болсон тухай, монгол овог аймгуудын зарим нь ч уг урсгалыг шүтэж, загалмайтан болсон товч түүхийг олж үзээрэй.

⁶ «Ромын пап ламын тэргүүлдэг христосын шашны нэгэн томоохон урсгал» [Монгол хэлний тайлбар толь / эрхэлсэн Хондогынхон Базаррагчаагийн Баярсайхан, эмхэтгэн редакторласан Олхонуд Ашваагийн Янжиндолгор. Улаанбаатар: МонСудар хэвлэлийн газар, 2011.

1865 онд тус бүлгэмээс Си.Ай.Си.Эм бүлгэмд [Пьер Палуссьер, 2011: 444-454] шилжүүлсэн байна. Үүний үр дүнд Ордосд Христийн шашин хамгийн хүчтэй дэлгэрчээ. Үүнд эртнээс нааш Христийн Несторий урсгалыг шүтэгч Эрхүүд нар ч нөлөөлсөн байх магадлалтай.

Харин буриадад 1825 оноос хойш Христийн шашин, Үнэн алдартны шашин түгэн дэлгэрчээ. Түүнээс хойш шашин түгээгч нар монгол хэл дээр библи судрыг орчуулах ажил эрчимжиж, 20 орчим библийн ном орчуулга, сургаалууд хэвлэгдэн тарааж байжээ.

Түүхээс үзвэл монголыг судлах оросуудын судалгаа 1800-аад оноос эрчимжиж, улмаар 1860 оны Бээжингийн гэрээгээр Оросын харьяат нар Хятад, Монгол руу чөлөөтэй нэвтрэх боломжтой болж, үүнийг дагаад 1861 оны 2-р сард Өргөөд Монголд анхны Оросын консулын газар [Даревская, 2011: 182, 186] байгуулагдсан нь Орос, Монголын харилцаанд шинэ шинэ боломжийг нээж өгчээ. Үүний үр дүнд оросын судлаачид, тэр дундаас Оросын Газар зүйн нийгэмлэгийн Дорнод Сибирийн Салбарын судлаач, аялагчдын алдартай бүтээл туурвилууд гарах болсон нь монголыг Орос, европ дахинд таниулахад ихээхэн үүрэг гүйцэтгэсэн юм.

Ингэж Европын зүгээс дорно дахиныг тэр дундаа Монголыг сонирхож, шашин сургаалаа түгээх нэрийн доор үйл ажиллагаа явуулж байсан нь монгол угсаатнууд харийн шашны нөлөөнд орох үндсэн шалтгаан болжээ.

Тиймээс ямар ч байсан «Гуяат лүндэн хэмээх судар оршив» ном нь 1800-аад оны сүүл багцаанд бичигдэж, олон түмэнд түгэн тархсан байх магадлал хамгийн өндөр байна. Нөгөө талаас Өвөрмонголын Ордос гэх мэт газарт Хятадад суурьшсан Христийн шашны Католик урсгалынхны нөлөө их байсан хэдий ч тухайн цагийн Ар монгол, халхуудад төдий л сүртэй нөлөө үзүүлж чадаагүй байдаг.

Харин буриад монголчууд нь Оросын мэдэлд байсан тул тэд эртнээс европ зүгийн тэр дундаас Оросын нөлөөнд эрт орсон юм. Монголчуудыг хуваан эзлэх түрэмгий бодлогын үр дүнд Оросын

төлөөлөгч элчин, тойрогийн захирагч Ф. А. Головин, Чин улсын бүрэн эрхэт төлөөлөгч Сонгот нар 1689 оны 8-р сарын 27-нд «Нерчугийн гэрээ» гэгчийг байгуулж, дараа нь Оросын элчин сайд С. Л. Владиславич-Рагузинский Манжийн бүрэн эрхэт төлөөлөгч Чабина, Тэгүт, Тулишен нар 1727 оны 10 сард Хиагтад хэлэлцээ хийж Соёны нурууны Шавийн даваанаас Эргүнэ голын Абагайтын толгой хүртэл хил тавих гэрээ байгуулсан байдаг. Энэ хил хязгаараар нийт монголчууд манжийн эрхшээлд, хоричууд буюу хожим буриад угсаатан болон төлөвшсөн бидний өвөг дээдэс Оросын эзэн хааны харьяанд бүрэн орсон байдаг [Одмандах, 2011: 156].

Энэ үйл явдлаас хойш буриадууд, тэр дундаа байгалийн баруун эргийн буриад монголчууд анх түрүүн Хэрээс зүүж Үнэн алдартны шашинд орох явдал түгээмэл болсныг түүхэнд тэмдэглэн үлдээснийг санах хэрэгтэй. Мөн 1834 онд Александр Бобровников гэдэг Буриадын христ шашны дээд санваартан өглөө орой уншдаг сүмийн ёслолын ном орчуулсан байдаг байна. 1847 онд Балаганскийн сургуулийн буриад багш Яков Болдонов гэгч Христос шашны анхны номыг кирилл үсгээр хэвлэсэн гэсэн тэмдэглэл [Арай Юкиясү, 2015: 7] ч байдаг байна.

Буриадууд Христийн шашны нөлөөнд автах явдал нь Оросын газрын эздийн түрэмгий байдал, амьдралын ядуу зүдүү амьдрал нь ч нөлөөлсөн байдгийг ардын дунд хэлцэх хэлц үгээс харж болно. Буриадуудын дунд «Хилээмэнэй түлөө хэрээхэнэг болохо» гэсэн хэлц бий бөгөөд «Өнөө маргаашаа харсан богино ухаан гаргах. Идэх юмны төлөө шашин шүтлэгээ өөрчлөх, Христийг шүтэх явдлыг шүүмжилсэн утгаар үүсч хэрэглэгдэх болсон» [Цэрэнчимэд, 2009: 25] байна. Энэ нь жирийн иргэдийн дунд ихээхэн эсэргүүцэлтэй тулж байсныг гэрчлэх бөгөөд христэд итгэсэн хүмүүсийг шүүмжилж байсныг гэрчилэх баримт юм.

Энэ бүхнээс дүгнэхэд монгол туургатнаас Өвөрмонголын Ордосынхон католик шашны нөлөөнд илүүтэй орсон бол буриад-монголчуудаас баруун буриадууд нь Үнэн алдартны шашны

